# II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

## Санамж

Захиалагч худалдан авах барааны онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн бараа нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
|---|---|
| **ТШЗ 1.1** | Захиалагч: ***Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газар*** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын нэр: ***Төрийн албан хаагчдад орон сууц худалдан авах*** |
| **ТШЗ 1.1** | Тендерийн урилгын дугаар: ***ДОАДБСЗДТГ/202308034*** |
| **ТШЗ 1.2** | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<br>***Багц № 1: Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого, Хөдөөгийн хөгжлийг дэмжих хүрээнд Дашбалбар сумын ИТХ-ын 05 дугаар тогтоол Орон сууц худалдан авах*** |
| **ТШЗ 1.3** | Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:<br>***Төрийн албан хаагчдад орон сууц худалдан авах*** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Дашбалбар сумын Орон нутгийн хөгжлийн сан*** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: ***93,000,000 төгрөг*** |
| **Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА** | |
| **ТШЗ 9.2** | Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:<br>Хүлээн авагчийн нэр: ***Дорнод аймаг Дашбалбар сум Засаг даргын Тамгын газрын дарга Ү.Бөхчулуун***<br>Хаяг: ***Дашбалбар сум Улз баг Цагаан дэв 2-р гудамж 207 тоот***<br>Утасны дугаар: ***70586606***<br>Цахим шуудангийн хаяг: ***Dashbalbar1@gmail.com*** |
| **ТШЗ 10.1** | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ***Үгүй*** |
| **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ** | |
| **ТШЗ 13.2** | Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: ***“Монгол хэл”*** |

<table>
<tr><td>ТШЗ 16.1</td><td>Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрнө”</td></tr>
<tr><td>ТШЗ 18.2</td><td>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:<br>Сүүлийн 1 жилийн хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 30 хувиас хувиас багагүй байх.<br>-Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээ<br>- Харилцагч банкны тодорхойлолт /хугацаа хэтэрсэн өргүй байх/<br>- Татварын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/<br>- Нийгмийн даатгалын тодорхойлолт<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт</td></tr>
<tr><td>ТШЗ 18.2.5</td><td>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: “Шаардана”</td></tr>
<tr><td>ТШЗ 18.3</td><td>Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021,2022 оны тайланг аудитын байгууллагаар баталгаажуулан ирүүлнэ.</td></tr>
<tr><td>ТШЗ 18.6</td><td>Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: : 2021,2022,2023 онд гүйцэтгэсэн ижил төстэй туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, тайлангийн хуулбар/;1-с доошгүй
<table>
<tr><td>№</td><td>Нэр төрөл</td><td>Тоо хэмжээ , шаардлага</td></tr>
<tr><td>1</td><td>Зориулалт</td><td>Орон сууц</td></tr>
<tr><td>2</td><td>Байрны талбайн хэмжээ</td><td>40м2-аас ихгүй</td></tr>
<tr><td>3</td><td>Таазны өндөр</td><td>Стандартын шаардлага хангасан байх</td></tr>
<tr><td>4</td><td>Нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон эсэх</td><td>Тийм</td></tr>
<tr><td>5</td><td>Байршил</td><td>Дашбалбар суманд байршилтай</td></tr>
<tr><td>6</td><td>Өрөөний зохион байгуулалт</td><td>1-2 өрөөтэй, ариун цэврийн өрөө тусдаа байна.</td></tr>
<tr><td>7</td><td>Ашиглалтанд орсон хугацаа</td><td>2023 онд ашиглалтанд орсон шинэ орон сууц</td></tr>
<tr><td>8</td><td colspan="2">Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байх</td></tr>
</table></td></tr>
<tr><td>ТШЗ 18.6.1</td><td>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”<br>Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанаас багагүй хугацаанд хүчинтэй байх</td></tr>
</table>

| | |
|---|---|
| | ***шаардлагатай.Техникийн санал тусгай зөвшөөрлийн баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ.*** |
| **ТШЗ 18.6.3** | Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: ***"Шаардана"***<br>***Хэрэв шаардах бол уг үйлчилгээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичиж ирүүлэх*** |
| **ТШЗ 18.6.4** | Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: ***"Шаардлагатай"*** |
| **ТШЗ 18.6.7** | Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: ***"Шаардахгүй"*** |
| **ТШЗ 18.6.8** | Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: ***"Шаардана" . Зөвхөн ТШЗ-ны 18.6.1-18.6.7-д зааснаас бусад мэдэгдэл, баримт бичгийг бичнэ. ТШЗ-ны 18.6-д заасан тендерт оролцогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэхгүй.*** |
| **ТШЗ 18.7.** | Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ***"Шаардахгүй"*** |
| **ТШЗ 19.5.** | Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх хугацаа:***Орон сууц нь 2023 онд ашиглалтанд орсон , цэвэр бохир ус , цахилгаан дулаанд холбогдсон байх*** |
| **ТШЗ 20.5.** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: ***"Тохируулахгүй тогтмол байна"*** |
| **ТШЗ 20.6** | Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх:***"Үгүй"*** |
| **ТШЗ 23.1** | Тендерийн баталгааны дүн: ***[Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувиар тооцох] 465000 төгрөг;*** |

| **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ** | |
|---|---|
| **ТШЗ 24.5.3** | ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:<br>***Тендер шалгаруулалтын журмын дагуу материал ирүүлэх*** |
| **ТШЗ 25.1.** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: |

| | |
|---|---|
| | Огноо: **2023 оны 11 дугаар сарын 03**<br>Цаг: ***10 цаг 00 минут*** |
| **ТШЗ 27.1.** | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: ***2023 оны 11 дугаар сарын 03***<br>Цаг: ***10 цаг 00 минут***<br>Тендер нээх газрын хаяг: ***Дорнод аймаг Дашбалбар сум Засаг даргын тамгын газар 2 давхар 9 тоот*** |
| **Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ** | |
| **ТШЗ 31.2** | Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: ***"Ашиглахгүй"*** |
| **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ** | |
| **ТШЗ 40.1** | Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: ***["Тийм" эсхүл "Үгүй" гэж бичих]***<br>***[Хэрэв "Тийм" гэж хариулсан бол доорх өгүүлбэрийг бичих:***<br>***ТШЗ-ны 8.5-т заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.]*** |
| **Ё. БУСАД** | |
| **ТШЗ 43.1** | Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: **Үгүй** |

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо[1] : ***2023 оны 10 дугаар сарын 03 ны өдөр***

Тендер шалгаруулалтын нэр: ***Төрийн албан хаагчдад орон сууц худалдан авах***

Тендер шалгаруулалтын дугаар: ***ДОАДБСЗДТГ/202308034***

***Дорнод аймгийн Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газар*** нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг ***Төрийн албан хаагчдад орон сууц худалдан авах***-ыг нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш [30] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заах ба ***[ 465,000 ]***[2] төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.[3]

Тендерийг ***2023.11.03-ны 10.00 цаг***–аас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг ***2023.11.03***-*ны өдрийн,* ***10:30мин***[4]-*т* зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх:[5]***"Эрхгүй"***
Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: ***"Үгүй"***

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Хүлээн авагчийн нэр: ***Дорнод аймаг Дашбалбар сум Засаг даргын Тамгын газрын дарга Ү.Бөхчулуун***

Хаяг: ***Дашбалбар сум Улз баг Цагаан дэв 2-р гудамж 207 тоот***

Утасны дугаар: ***70586606***

Цахим шуудангийн хаяг: ***Dashbalbar1@gmail.com***

---

1 Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.
2 Төсөвт өртгийн 1/2 хувьтай тэнцүү байна.
3 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 70 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, зөвлөхөөс бусад үйлчилгээ худалдан авахад тендерийн баталгаа шаардана.
4 Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.
5 Хуулийн 9.3-т зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно.